



**ХЭНТИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар A/62

Бор-Өндөр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.1.19 дахь заалт, Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1, Авто тээврийн хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь хэсэг, Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/37 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд авто тээврийн хэрэгслийн татвар хураалт, техникийн хяналтын үзлэгийг 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.
2. Авто тээврийн хэрэгслийн бүртгэл, техникийн хяналтын үзлэгийн ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Х.Галбадрах

Засаг даргын орлогч

Нарийн бичиг:

Ч.Саруулмөнх

Уурхайчин 4 дүгээр багийн Засаг дарга

Гишүүд:

И.Энхтуяа

Бор-Өндөр 1 дүгээр багийн Засаг дарга

У.Пүрэвсүрэн

Холбоо 2 дугаар багийн Засаг дарга

Д.Мөнгөнтуяа

Бумбат 3 дугаар багийн Засаг дарга

Б.Мөнх-Оргил

Хүйх 5 дугаар багийн Засаг дарга

Н.Отгонбилэг

Өлгий 6 дугаар багийн Засаг дарга

Б.Батбаяр

Татварын байцаагч

Ц.Баясгалан

Татварын Улсын ахлах байцаагч

Б.Хүрэлбаатар

Замын цагдаагийн зохицуулагч, цагдаагийн

Ахлах дэслэгч


3. Авто тээврийн хэрэгслийн хяналтын үзлэгийг өөрийн нутаг дэвсгэрт байгаа бүх тээврийн хэрэгслийг бүртгэл судалгааны дагуу бүрэн хамруулах, техникийн үзлэгт авто тээврийн хэрэгслийн албан татварыг хураан авах ажлыг зохион байгуулан хэрэгжилтийг хангаж ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

4. Тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл гаргаж, хуваарьт өдөр комисс ажиллах нөхцлийг бүрдүүлж, техник хяналтын үзлэг явуулах байр, талбайн бэлтгэлийг хангаж, техник хяналтын үзлэгт тээврийн хэрэгслүүдийг бүрэн хамруулж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Хуваарийн дагуу явагдсан авто тээврийн хэрэгслийн татвар хураалт, техникийн хяналтын үзлэгт ороогүй тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцохыг хориглох, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллахыг Бор-Өндөр сум дахь Цагдаагийн хэлтсийн дарга (дэд хурандаа Т.Энхбаяр)-д даалгасугай.

6. Тээврийн хэрэгслийн татвар хураалт, техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагааг танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Х.Галбадрах)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г А Д Ъ Я А Б И Л Э Г Т